



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН
НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН
ТАЙЛАН

АУДИТЫН КОД: СНАГ-2023/19/НА-СТА-ТТЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Санхүү, нийцлийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Ц.Хосжаргал
Утас: 261885 Цахим хаяг: Khosjargalts@audit.gov.mn
Ахлах аудитор: В.Эрдэнэцогт
Утас: 261628 Цахим хаяг: erdenetsogtv@audit.gov.mn
Аудитор: С.Отгонхорлоо
Утас: 261628 Цахим хаяг: Otgonkhorloos@audit.gov.mn

Улаанбаатар хот
2023 он

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН.....	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	6
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	13
3.4.1 Мөнгөн хөрөнгө.....	14
3.5.2 Авлага.....	15
3.5.3 Урьдчилгаа.....	15
3.5.4 Бараа материал.....	15
3.5.6 Бусад эргэлтийн хөрөнгө.....	16
3.5.8 Үндсэн хөрөнгө.....	17
3.5.9 Өр төлбөр.....	17
3.5.10 Засгийн газрын хувь оролцоо.....	18
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	20
4.1 Ерөнхий зүйл.....	20
4.2 Материаллаг байдал.....	20
4.5 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	20
4.6 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	21
4.6.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	21
4.7 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	21
4.7.1 Завсрын аудитын талаар.....	21
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	22
5.1 Албан шаардлага.....	22
5.2 Зөвлөмж.....	23
6. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ.....	24

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НУБГ	Нийслэлийн улсын бүртгэлийн газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар
ХЗБХЯ	Хууль зүй дотоод хэргийн яам





УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДАРГА Д.ДЭЛГЭРСАЙХАН ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас 26-04-37, Факс: 51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2023.03.24 № 01/664
ганай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд иргэдэд үйлчлэх үйлчилгээний нэгдсэн цэгийг 5 газар шинээр нэмж байгуулсан, гадаад паспортын зургийг бүртгэгч өөрөө авах боломжтой болсноор иргэдэд түргэн шуурхай үйлчилж, үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлсэн байна.

Үндсэн хөрөнгийн QR коджуулалт хийх программыг 16.8 сая төгрөгөөр худалдан авч байгууллагын хөрөнгийг цахим бүртгэлд оруулснаар хөрөнгийн тооллого хийх, тооцоо бодох, ашиглалт, хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналтыг сайжруулжээ.

Аудитын гол асуудал

Гадаад паспортын бичилтийг гүйцэтгүүлэх Титан интернэшнл ХХК-тай байгуулсан гэрээ дуусгавар болж, 2022 оны 10 дугаар сараас эхлэн үйлдвэрийг тус байгууллагын үйл ажиллагаанд нэгтгэснээр 3,489.3 сая төгрөгийн орлого бүрдүүлж, улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Бусад мэдээлэл

Байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 1 зорилтын хүрээнд 7 арга хэмжээ төлөвлөснөөс хэрэгжилтийг 98.0 хувь гэж үнэлсэн байна.

Z:\Yawsan_Bichig\2023\0315 SNAG-120-121 Docx

0001051302

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ



Я.САРАНСҮХ

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	13,132,532.6	13,809,951.2
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	893,013.4	120,435.9
33	АВЛАГА	39,715.6	835,265.5
34	УРЬДЧИЛГАА	-	3,789.1
35	БАРАА МАТЕРИАЛ	12,099,803.6	9,780,460.7
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	100,000.0	3,070,000.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	40,561,833.6	49,394,138.1
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	40,561,833.6	49,394,138.1
39200	Биет хөрөнгө	38,929,543.0	35,404,096.6
39300	Биет бус хөрөнгө	1,632,290.6	13,990,041.5
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	53,694,366.2	63,204,089.3
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	887,892.7	178,204.1
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	887,892.7	178,204.1
41300	Өглөг	1,698.7	84,211.5
41400	Урьдчилж орсон орлого	886,194.0	93,992.6
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	52,806,473.5	63,025,885.2
51	Засгийн газрын хувь оролцоо	52,806,473.5	63,025,885.2
51100	Засгийн газрын оруулсан капитал	12,211,503.2	12,211,503.2
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	12,211,503.2	12,211,503.2
51200	Хуримтлагдсан үр дүн	40,084,186.0	50,303,597.7
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	510,784.3	510,784.3
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	53,694,366.2	63,204,089.3

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	59,089,504.6	53,428,597.1
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	12,642,751.2	14,207,410.8
120	Нийтлэг татварын бус орлого	12,642,751.2	14,207,410.8
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	46,446,753.4	39,221,186.2
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	37,847,798.0	42,875,800.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	37,847,798.0	42,875,800.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	37,013,051.6	41,337,290.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	16,848,089.1	16,460,178.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,322,879.1	2,161,605.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,062,937.6	897,025.2
2104	Хангамж, бараа материалын зардал	2,033,906.1	1,680,264.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	222,168.9	140,804.8
2107	Томилолт, зочны зардал	19,003.4	18,179.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,142,732.7	9,945,730.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,361,334.8	10,033,503.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	834,746.4	1,538,509.9
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	21,241,706.6	10,552,796.4
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	2,409,597.8	337,854.2
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	18,832,108.8	10,214,942.2



Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	33,889,372.4	-	33,889,372.4
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	84,992.4	-	84,992.4
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	33,974,364.7	-	33,974,364.7
9	Тайлант үеийн үр дүн	18,832,108.8	-	18,832,108.8
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	52,806,473.5	-	52,806,473.5
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	4,469.5	-	4,469.5
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	52,810,943.0	-	52,810,943.0
19	Тайлант үеийн үр дүн	10,214,942.2	-	10,214,942.2
20	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	63,025,885.2	-	63,025,885.2

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	66,762,206.2	65,316,576.0
11	ТАТВАРЫН ОРЛОГО	19,142,988.1	26,011,255.8
118	Бусад татвар, төлбөр, хураамж	19,142,988.1	26,011,255.8
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	19,142,988.1	26,011,255.8
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,171,464.7	84,134.0
120	Нийтлэг татварын бус орлого	1,171,464.7	84,134.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	46,447,753.4	39,221,186.2
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	52,768,249.5	61,791,727.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	52,768,249.5	61,791,727.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	32,827,941.6	34,227,962.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	16,461,284.9	16,380,666.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,588,361.1	2,205,620.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,063,415.3	900,877.8
2104	Хангамж, бараа материалын зардал	794,666.2	869,014.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	166,692.2	703,297.9
2107	Томилолт, зочны зардал	19,032.6	18,179.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,457,021.5	11,544,170.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,277,467.8	1,606,135.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	19,940,308.0	27,563,764.2
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	13,993,956.7	3,524,848.9
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	13,207,952.3	4,297,426.5
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	13,207,952.3	4,297,426.5
2200	Дотоод эх үүсвэрээр	13,207,952.3	4,297,426.5
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(13,207,952.3)	(4,297,426.5)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	786,004.4	(772,577.6)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	107,009.0	893,013.4
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	893,013.4	120,435.9



Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	30,308,235,000.00	30,222,739,619.97	85,495,380.03	99.7
УРСГАЛ ЗАРДАЛ	27,338,235,000.00	27,252,739,620.97	85,495,379.03	99.7
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	26,354,987,900.00	26,274,586,544.97	80,401,355.03	99.7
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	16,375,901,400.00	16,359,754,741.44	16,146,658.56	99.9
Үндсэн цалин	12,781,695,700.00	12,413,312,793.44	368,382,906.56	97.1
Нэмэгдэл	2,310,471,000.00	2,698,204,808.57	(387,733,808.57)	116.8
Унаа хоолны хөнгөлөлт	1,074,370,200.00	1,020,145,814.25	54,224,385.75	95.0
Урамшуулал	207,264,500.00	226,074,349.72	(18,809,849.72)	109.1
Гэрээт ажлын хөлс	2,100,000.00	2,016,975.46	83,024.54	96.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,218,378,300.00	2,202,983,918.11	15,394,381.89	99.3
Тэтгэврийн даатгал	1,562,789,300.00	1,549,321,326.92	13,467,973.08	99.1
Тэтгэмжийн даатгал	165,117,700.00	165,689,584.85	(571,884.85)	100.3
ҮОМШӨ-ний даатгал	130,185,700.00	129,909,197.03	276,502.97	99.8
Ажилгүйдлийн даатгал	33,249,800.00	33,281,638.72	(31,838.70)	100.1
Эрүүл мэндийн даатгал	327,035,800.00	324,782,170.59	2,253,629.41	99.3
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	909,496,100.00	896,277,813.75	13,218,286.25	98.5
Гэрэл, цахилгаан	197,055,900.00	201,742,035.23	(4,686,135.23)	102.4
Түлш, халаалт	357,925,700.00	341,423,102.20	16,502,597.80	95.4
Цэвэр, бохир ус	34,411,300.00	33,668,176.32	743,123.68	97.8
Байрны түрээс	320,103,200.00	319,444,500.00	658,700.00	99.8
Хангамж, бараа материалын зардал	889,230,500.00	873,049,917.51	16,180,582.49	98.2
Бичиг хэрэг	450,144,700.00	452,949,091.00	(2,804,391.00)	100.6
Тээвэр, шатахуун	110,858,200.00	108,883,407.86	1,974,792.14	98.2
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	128,128,700.00	119,711,319.81	8,417,380.19	93.4
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	12,278,400.00	11,567,703.84	710,696.16	94.2
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	187,820,500.00	179,938,395.00	7,882,105.00	95.8
Эд хогшил, урсгал засварын зардал	802,599,100.00	793,880,430.20	8,718,669.80	98.9
Багаж, техник, хэрэгсэл	609,480,300.00	585,280,259.00	24,200,041.00	96.0
Тавилга	80,000,000.00	99,417,600.00	(19,417,600.00)	124.3
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	27,974,000.00	25,601,114.00	2,372,886.00	91.5
Урсгал засвар	85,144,800.00	83,581,457.20	1,563,342.80	98.2
Томилолт, зочны зардал	13,681,500.00	13,355,500.00	326,000.00	97.6
Дотоод албан томилолт	13,681,500.00	13,355,500.00	326,000.00	97.6
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,759,256,200.00	3,749,829,645.34	9,426,554.66	99.7
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,192,710,200.00	2,185,137,327.00	7,572,873.00	99.7
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	10,761,400.00	9,746,928.00	1,014,472.00	90.6

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Даатгалын үйлчилгээ	10,113,000.00	9,752,343.00	360,657.00	96.4
Тээврийн хэрэгслийн татвар	2,887,400.00	2,585,637.00	301,763.00	89.5
Тээврийн хэрэгслийн оношилгоо	396,000.00	396,000.00	-	100.0
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	854,934,400.00	854,895,100.00	39,300.00	100.0
Газрын төлбөр	1,018,100.00	891,877.00	126,223.00	87.6
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	172,600.00	161,361.00	11,239.00	93.5
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	686,263,100.00	686,263,072.34	27.66	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	1,386,444,800.00	1,385,454,578.62	990,221.38	99.9
Бараа үйлчилгээний бусад зардал	1,174,990,400.00	1,174,938,799.62	51,600.38	100.0
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	211,454,400.00	210,515,779.00	938,621.00	99.6
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	983,247,100.00	978,153,076.00	5,094,024.00	99.5
Бусад урсгал шилжүүлэг	983,247,100.00	978,153,076.00	5,094,024.00	99.5
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	875,864,300.00	875,152,929.00	711,371.00	99.9
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	107,382,800.00	103,000,147.00	4,382,653.00	95.9
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,970,000,000.00	2,969,999,999.00	1.00	100.0
Барилга байгууламж	2,970,000,000.00	2,969,999,999.00	1.00	100.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	30,308,235,000.00	30,222,739,619.97	85,495,380.03	99.7
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	30,308,235,000.00	30,222,739,619.97	85,495,380.03	99.7
Улсын төсвөөс санхүүжих	30,308,235,000.00	30,222,739,619.97	85,495,380.03	99.7
БАЙГУУЛЛАГЫН ТОО	23	23	-	100.0
Төсвийн байгууллага	23	23	-	100.0
АЖИЛЛАГСДЫН ТОО	1268	1268	-	100.0
Удирдах ажилтан	40	40	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	1116	1116	-	100.0
Үйлчлэх ажилтан	64	64	-	100.0
Гэрээт ажилтан	48	48	-	100.0



Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	9,023,090,312.53
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	8,661,981,412.53
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	8,186,888,059.53
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	20,911,416.00
210101	Үндсэн цалин	-	2,067,187.00
210105	Гэрээт ажлын хөлс	-	18,844,229.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	2,636,466.00
210201	Тэтгэврийн даатгал	-	2,026,249.64
210202	Тэтгэмжийн даатгал	-	152,554.09
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	122,043.27
210204	Ажилгүйдлийн даатгал	-	30,510.82
210205	Эрүүл мэндийн даатгал	-	305,108.18
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	4,600,000.00
210304	Байрны түрээс	-	4,600,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	6,835,450.00
210401	Бичиг хэрэг	-	2,887,900.00
210402	Тээвэр, шатахуун	-	2,952,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	995,550.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	35,737,450.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	22,880,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	650,000.00
210604	Урсгал засвар	-	12,207,450.00
2107	Томилолт, зочны зардал	-	4,824,000.00
210702	Дотоод албан томилолт	-	4,824,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	7,782,750,051.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	7,782,750,051.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	328,593,226.53
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	322,768,226.53
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	5,825,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	475,093,353.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	12,075,011.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	12,075,011.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	463,018,342.00
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	463,018,342.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	361,108,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	361,108,900.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	361,108,900.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	9,023,090,312.53
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	9,023,090,312.53
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	8,911,662,112.53

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	107,225,200.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	4,203,000.00



3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Улсын бүртгэлийн ерөнхий газар нь Монгол Улсын төр засгаас улсын бүртгэлийн чиглэлээр баримтлах бодлогыг хэрэгжүүлж, иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг иргэд, олон нийтэд чанартай, шуурхай хүргэх, оюуны өмчийн эрхийн хамгаалалт, хэрэгжилтийг хангах, улсын бүртгэлийн үйл ажиллагааг хууль тогтоомжид заасан үйл ажиллагааны үндсэн болон бусад чиг үүргийг хэрэгжүүлж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төрийн хэмнэлтийн тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Сангийн сайдын 2022 оны "Албан томилолтын зардлын тариф шинэчлэн батлах тухай" 120 дугаар тушаал;
- Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны "Журам батлах тухай-Өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам" 65 дугаар тогтоол;

Мөн дараах Захиргааны хэм хэмжээний 2 актыг улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлжээ. Үүнд:

- "Монгол Улсын 16 насанд хүрсэн иргэнд тоон гарын үсгийн гэрчилгээ олгох, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох журам"-ыг боловсруулж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 5827 дугаарт;
- Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2022 оны "Тушаалд өөрчлөлт оруулж, маягтын загвар батлах тухай" А/427 дугаар тушаалаар баталсан ЭУБ-06 маягт, ЭУБ-13 маягтыг Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар нь ЗГ-ын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, тухай бүр зөвлөмж өгч ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Улсын бүртгэлийн ерөнхий газар 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2017 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн А/904 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Нийт хөрөнгө өмнөх оноос 6,512.9 сая төгрөгөөр буюу 11.0 хувиар өссөн байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 120.3 сая төгрөг болж, өмнөх оноос 772.7 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/ сая төгрөг/ Өсөлт(+), Бууралт(-) 3=2-1
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	893.0	120.3	(772.7)
Банканд байгаа бэлэн мөнгө	847.3	120.3	(727.0)
Төгрөг	847.3	120.3	(727.0)
Төрийн сангийн харилцах	840.6	79.3	(761.3)
Арилжааны банк дахь харилцах	6.7	41.0	34.3
Замд яваа мөнгөн хөрөнгө	45.7	-	(45.7)

Эх сурвалж: Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл буурсан нь Хос бар ХХК-ийн гүйцэтгэсэн УБЕГ-ын барилгын их засварын 2021 оны барьцаа 747.3 сая төгрөг чөлөөлсөн нь голлон нөлөөлсөн байна. Арилжааны банкны харилцах дансанд байршиж буй үйлчилгээний орлого Дархан-Уул аймгийн УБГ 9.0 сая, Өвөрхангай аймгийн УБГ 4.0 сая, Булган аймгийн УБГ 2.1 сая, Увс аймгийн УБГ 1.7 сая, Орхон аймаг 1.6 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, НУБГ-ын 9.1 сая төгрөгөөр хасагдсан байна.

Аудитын илрүүлэлт:

- Шатахууныг илүү зарцуулсан, тооцооны дансаар дамжуулаагүй, зардалд шууд тусгасан, жолоочийн тооцоо бодоогүй 4.8 сая төгрөгийн зөрчил /Архангай аймгийн УБХ 1.7 сая, Булган аймгийн УБХ 3.1 сая/
- Өмнөговь аймгийн УБХ бага үнэтэй түргэн элэгдэх барааны зардалд 0.1 сая шатахууныг бүртгэсэн;
- Говь-Алтай аймгийн УБХ түлш халаалтын зардлыг 0.1 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан;
- Ховд аймгийн УБХ цалинг 0.6 сая төгрөгөөр илүү тооцоолж олгосон;
- НУБГ түлш халаалтын зардлаас 3.3 сая төгрөгийг цэвэр бохир усны зардалд шилжүүлэн зарцуулсан, 39.2 сая төгрөгийн бараа, ажил үйлчилгээний шууд гэрээ байгуулж, худалдан авалт хийсэн 39.2 сая төгрөг байна;
- УБЕГ нь гадаад томилолтын зардалд 172.3 сая, сургалтын зардалд 19.8 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.



Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 835.2 сая төгрөг болж, өмнөх оноос 795.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/
			Өсөлт (+), Бууралт (-)
Б	1	2	3=2-1
Ажиллагчтай холбогдсон авлага	1.4	3.9	2.5
Бусад авлага	38.3	831.3	793
Байгууллагаас авах авлага	38.3	811.1	772.8
Хувь хүмүүсээс авах авлага	-	20.2	20.2
Дүн	39.7	835.2	795.5

Эх сурвалж: Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын дансны үлдэгдэл 795.5 сая төгрөгөөр өссөн нь тайлант оны сүүлд Лүндээ-Очир ХХК, Сити сейф ХХК харилцагч байгууллагуудаас 22 нэгж нь архивын нягтруулсан шүүгээг нийт 447.5 сая төгрөгөөр худалдан авч авлага үүссэн, Мигасон ХХК цахим гадаад паспортын бэлдэц 348.0 сая төгрөгийн авлага тус тус голлон нөлөөлжээ.

Аудитын илрүүлэлт:

Сити сейф ХХК-тай архивын нягтруулсан шүүгээг нийлүүлэх нийт 59.5 сая төгрөгийн гэрээг /Төв аймгийн УБХ 19.8 сая, Баянхонгор аймгийн УБХ 19.9 сая, Орхон аймгийн УБХ 19.8 сая төгрөгөөр тус тус байгуулан тайлант оны авлагыг нэмэгдүүлсэн.

3.5.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эцсийн үлдэгдэл 3.7 сая төгрөг болж нэмэгдсэн байна.

Хүснэгт 3. Урьдчилгаа дансны үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/
			Өсөлт (+), Бууралт (-)
Б	1	2	3=2-1
УРЬДЧИЛГАА ДҮН	-	3.7	3.7
Урьдчилж гарсан зардал	-	3.7	3.7

Эх сурвалж: Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилж гарсан зардал дансны үлдэгдэлд 3.7 сая төгрөгөөр нэмэгдсэн нь НУБГ нь гэрэл цахилгаан зардлыг урьдчилан шилжүүлсэнтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

- НУБГ нь оны эцэст цахилгааны зардлын 3.7 сая төгрөгийн төлбөрийг урьдчилан шилжүүлсэн.

3.5.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 9,780.4 сая төгрөг болж, өмнөх оноос 2,319.1 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 4. Бараа материалын үлдэгдэл

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Б	1	2	3=2-1
Бараа материал	12,099.5	9,780.4	(2,319.1)
Түүхий эд материал	10,726.0	8,725.7	(2,000.3)
Тусгай зориулалттай материал	8,304.4	6,829.9	(1,474.5)
Бэлэн бүтээгдэхүүн	2,421.6	1,895.8	(525.8)
Хангамжийн материал	1,342.9	1,025.6	(317.3)
Бичиг хэргийн материал	301.4	342.8	41.4
Аж ахуйн материал	490.5	326.5	(164.0)
Сэлбэг хэрэгсэл	189.2	74.0	(115.2)
Түлш, шатах тослох материал	10.4	6.3	(4.1)
Барилгын засварын материал	0.1	-	(0.1)
Бусад хангамжийн материал	351.3	276.0	(75.3)
Биологийн хөрөнгө	-	-	-
Мал амьтад	30.6	29.1	(1.5)

Эх сурвалж: Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд бараа материал худалдан авсан 6,966.7 сая, балансаас баланст шилжүүлэн авсан 3,286.0 сая, бараа материалаас үндсэн хөрөнгөд шилжүүлэн бүртгэсэн 8.3 сая, нийт 10,261.8 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, зарцуулсан 8,488.5 сая, шилжүүлсэн 3,549.9 сая, аж ахуйн хангамжийн материалыг акталж устгасан 542.7 сая, нийт 12,581.6 сая төгрөгөөр хасагдсан байна.

Бараа материалаас акталсан УБЕГ-ын даргын А/194 тоот тушаалаар аж, ахуй хангамжийн материалын 503.9 сая, НУБГ болон 21 аймгийн улсын бүртгэлийн хэлтсүүдийн алдаатай, хүчингүй болгосон үнэт цаасны 31.8 сая, үнэ төлбөргүй шилжүүлсэн хурууны хээ уншигч төхөөрөмж 143.8 сая төгрөгөөр тус тус хасагдсан нь бууралтад голлон нөлөөлжээ.

Аудитын илрүүлэлт:

- Орхон аймгийн УБГ бараа материалын зардлыг зөвхөн шаардах хуудаст үндэслэн бүртгэсэн, зарлагын баримт хөтлөөгүй.

3.5.6 Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл 3,069.9 сая төгрөг болж, өмнөх оноос 2,969.9 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Бусад эргэлтийн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Б	1	2	3=2-1
БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	100.0	3,069.9	2,969.9
Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/+Бусад	100.0	3,069.9	2,969.9

Эх сурвалж: Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бусад эргэлтийн хөрөнгийн дансны үлдэгдэлд улсын төсвийн хөрөнгө оруулалтын 2022 онд



Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2,969.9 сая төгрөгийн Ховд, Хэнтий аймгуудын улсын бүртгэлийн хэлтсийн архив, конторын зориулалтаар баригдаж буй дуусаагүй барилгуудын гүйцэтгэл бүртгэлтэй байна.

3.5.8 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 49,394.1 сая төгрөг болж, өмнөх оноос 8,832.3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 6. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/
			Өсөлт (+), Бууралт (-)
Б	1	2	3=2-1
Эргэлтийн бус хөрөнгө	40,561.8	49,394.1	(8,832.3)
Биет хөрөнгө	38,929.5	35,404.1	3,525.4
Барилга, байгууламж, орон сууц	19,772.0	19,274.5	497.5
Авто-тээврийн хэрэгсэл	1,240.4	1,074.1	166.3
Машин тоног төхөөрөмж (компьютер)	16,786.0	13,912.8	2,873.2
Тавилга, аж ахуйн эд хогшил	1,101.8	1,116.7	(14.9)
Зам, гүүр байгууламж	19.5	18.5	1.0
Бусад үндсэн хөрөнгө	9.8	7.5	2.3
Биет бус хөрөнгө	1,632.3	13,990.0	(12,357.7)
Программ хангамж	1,396.8	13,749.0	(12,352.2)
Бусад биет бус хөрөнгө	235.5	241.0	(5.5)

Эх сурвалж: Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгө өөрийн хөрөнгөөр бэлтгэсэн 1,327.4 сая, балансаас баланст шилжүүлэн авсан 14,736.1 сая, бусад эх үүсвэрээр 91.0 сая, дахин үнэлгээний нэмэгдэл 261.9 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, акталсан 4,873.8 сая, балансаас баланст шилжүүлсэн 1,008.0 сая, дахин үнэлгээний хорогдол 792.2 сая төгрөгөөр тус тус хасагдсан байна.

Тайлант оны үндсэн хөрөнгийн үлдэгдлийн өсөлт ХЗДХЯ-ны нэг иргэн нэг бүртгэл төслөөс шилжүүлэн өгсөн 13,688.0 сая төгрөгийн тоног, төхөөрөмж, программ хангамжийн дүнгээр нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

Аудитын илрүүлэлт:

- УБЕГ /аппарат/ Засгийн газрын тогтоолоор автобазад 49.2 сая төгрөгийн суудлын автомашин хүлээлгэн өгсөн ч ТӨБЗГ-ын данс бүртгэлээс хасах шийдвэр гараагүй, биетээр оршин байхгүй;
- УБЕГ /аппарат/ урсгал төсвөөс 951.8 сая төгрөгийн компьютер, тоног төхөөрөмжийг бэлтгэсэн;
- Дархан-Уул аймгийн УБХ элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үндсэн хөрөнгийн цаашид ашиглах хугацаа, шинэчлэн тогтоох үнийг боловсруулж холбогдох байгууллагад хүргүүлээгүй.

3.5.9 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 178.2 сая төгрөг болж, өмнөх оноос 709.6 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 7. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/
			Өсөлт (+), Бууралт (-)
Богино хугацаат өр төлбөр	887.9	178.2	(709.7)
Өглөг	-	3.3	3.3
Ажилчидтай холбогдсон өглөг	-	3.3	3.3

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	-	-
Бусад өглөг	1.7	80.8	79.2
Байгууллагад өгөх өглөг	1.6	80.8	79.2
Урьдчилж орсон орлого	886.2	94.1	792.1
Засгийн газрын байгууллага, бусад шашны төсөв	51.3	41.0	(10.3)
Барьцаа, дэнчингийн урьдчилж орсон орлого	834.9	53.1	(781.8)

Эх сурвалж: Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэл 178.2 сая төгрөг болж өмнөх оноос 709.6 сая төгрөгөөр буурсан нь УБЕГ-ын барьцаа, дэнчингийн өглөг 725.1 сая, НУБГ-ын улсын төсөвт төвлөрүүлэх орлогын үлдэгдэл 6.1 сая төгрөгийг тус тус барагдуулснаас шалтгаалжээ.

Аудитын илрүүлэлт:

- Сэлэнгэ аймгийн УБГ 0.1 сая өмнөх жилийн ариутгалын ажлын төлбөрийг өглөг үүсгээгүй, тайлант жилийн зардлаар бүртгэсэн;
- Говьсүмбэр аймгийн УБГ 0.7 сая төгрөгийн өр төлбөрийн тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

3.5.10 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 63,025.8 сая төгрөг болж, өмнөх оноос 10,219.3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 8. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Б	1	2	3=2-1
Засгийн газрын хувь оролцоо	52,806.5	63,025.8	10,219.3
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	12,211.5	12,211.5	-
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	12,211.5	12,211.5	-
Хуримтлагдсан үр дүн	40,595.0	50,814.3	10,219.3
Өмнөх үеийн үр дүн	21,252.1	40,088.6	18,836.5
Тайлант үеийн үр дүн	18,832.1	10,214.9	(8,617.2)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	510.8	510.8	-

Эх сурвалж: Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо данс 10,219.3 сая төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүн нэмэгдсэнтэй холбоотой байна. УБЕГ-ын тоног, төхөөрөмж, программ хангамжийн 13,800.0 сая төгрөгийн үнэ төлбөргүй шилжүүлэн авсныг орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэсэн нь голлон нөлөөлсөн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт



Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд нийт зарлагыг 66,576.5 сая төгрөгөөр боловсруулж, санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс бүрдүүлэхээр тооцож, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслөөс урсгал зардлыг 7,809.8 сая, хөрөнгийн зардлыг 29,939.4 сая төгрөгөөр тус тус бууруулж, 28,827.2 сая төгрөгөөр баталсан байна. Энэ нь төсвийн төслийг боловсруулахдаа хөрөнгийн зардалд барилга байгууламжийг 15,265.8 сая, их засварын зардлыг 1,326.6 сая, тоног, төхөөрөмж бэлтгэх зардлыг 13,347.0 сая төгрөгөөр бодитой бус төлөвлөснийг бууруулсан байна.

Тайлант онд төсвийг 2 удаа тодотгож, анхны баталсан төсвөөс 1,517.0 сая төгрөгөөр бууруулж, төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээнд зориулж 30,308.2 сая төгрөгийн зарлагыг улсын төсвөөс санхүүжүүлэхээр баталсан байна. Мөн Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулиар 23,800.0 сая төгрөгийн орлого бүрдүүлэхээр тусгажээ.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс урсгал зардлын 27,335.5 сая төгрөгийн, хөрөнгийн 2,970.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого 23,416.0 сая төгрөгийг бүрдүүлж, улсын төсөвт, орон нутгийн тэмдэгтийн хураамж 1,517.7 сая, торгууль 1,090.6 сая, арилжааны банкны эхний үлдэгдэл 52.4 сая төгрөгийг тус тус орон нутгийн орлогын дансанд төвлөрүүлжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 27,252.7 сая төгрөг буюу 99.7 хувьтай байна.

Санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдэл 82.6 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 9. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
70406	Улсын бүртгэл, мэдээлэл	30,308,235.0	30,222,739.6	85,495.3	99.7
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	23,062,353.8	22,985,389.4	76,964.3	99.6
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж	983,247.1	978,153.0	5,094.0	99.4
80220	Холбооны суваг ашигласны хөлс	542,457.6	542,416.0	41.5	99.9
80205	Мэдээлэл сурталчилгааны зардал	13,706.8	10,631.4	3,075.4	77.5
80226	Байр ашиглалтын үйлчилгээ	22,831.9	22,810.8	21.0	99.9
81521	Иргэний үнэмлэх хэвлэж гараах	2,713,637.8	2,713,338.8	299.0	99.9
80918	Бусад	2,970,000.0	2,969,999.9	-	100.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Санхүүжилт болох дээд шатны төсөв захирагчаас орон нутгийн нөхөн сонгуулийн 107.2 сая, ЗДНХ-өөс 8,911.7 сая, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт байрны түрээсийн орлого 4.2 сая нийт 9,023.1 сая төгрөгийн эх үүсвэрийг тус тус бүрдүүлжээ.

Гүйцэтгэлээр цалин хөлс, нэмэгдэл урамшуулалд 20.9 сая, НДШ-ийн зардалд 2.6 сая, байрны түрээсийн төлбөрт 4.6 сая, хангамж бараа материалын зардалд 6.8 сая, эд хогшил, урсгал засварын зардалд 35.7 сая, дотоод албан томилотод 4.8 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжид 7,782.8 сая, бараа үйлчилгээний бусад зардалд 328.6 сая, нэг удаагийн тэтгэмж урамшуулалд 12.1 сая, биет бус хөрөнгө худалдахад 61.1 сая төгрөгийг тус тус зарцуулж, улсын төсөвт 463.0 сая төгрөгийг буцаан төвлөрүүлжээ.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, үнэт цаасны тооцоотой холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Санхүү-Нийцлийн аудитын газрын аудитор С.Отгонхорлоо гүйцэтгэж, ахлах аудитор В.Эрдэнэцогт анхан шатны хяналтыг хэрэгжүүлж, хяналтыг аудитын менежер Ц.Хосжаргал, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч Я.Сарансүх нар тус тус хэрэгжүүлсэн.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2023 оны 3 дугаар сарын 03-ны өдрийн 1/188 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 42,875.8 сая төгрөгөөс 1.5 хувиар тооцож буюу 643.1 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.5 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллага дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэн нийт 5,099.6 сая төгрөгийг хэмнэсэн байна. Үүнд:
СНАГ-2023/19/НА-СТА-ТТЗ

20



Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

- УБЕГ-ын 2 дэд даргыг ажлаас чөлөөлснөөр цалин, нийгмийн даатгалын шимтгэл, шатахууны зардлыг тодорхой хувиар бууруулсан;
- Сургалт семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулсан, иргэдэд үзүүлж байгаа төрийн үйлчилгээг E-Mongolia болон цахимаар авах боломжийг бүрдүүлснээр маягт болон бичиг хэргийн зардлыг;
- Харьяа орон нутгийн хэлтсүүдэд хийх шалгалтыг цахимаар хийх боломжийг нэвтрүүлж, тээвэр шатахууны зардлыг хэмнэсэн;
- ТӨБЗГ-ын 2022 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн А-1/1010 тоот албан бичгийн дагуу тус газарт бүртгэлтэй Ландкрузер-100, 105, Киа серато маркийн автомашинуудыг Засгийн газрын автобаазад хүлээлгэн өгсөн;
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх Баян-Өлгий аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн барилгын ажлын санхүүжилтийг хойшлуулсан.

4.6 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.6.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын харьяа байгууллагуудын хэмжээнд шилэн дансны цахим хуудсанд 3 байгууллага 1353.4 сая төгрөгийн мэдээллийг хугацаанд нь мэдээлээгүй зөрчил илэрсэн байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 4.1.3, 6 дугаар зүйлийн 6.4.5 дахь заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалтыг бүрэн хэрэгжүүлээгүй 1 байгууллагын 1,353.4 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 2 байгууллагын зөрчилд зөвлөмж өгсөн байна.

4.7 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.7.1 Завсрын аудитын талаар

Улсын бүртгэлийн ерөнхий газрын төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа 1 төсвийн шууд захирагчийн 2022 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийж, тус аудитаар илэрсэн алдаа зөрчлийг жилийн эцсийн байдлаар нэгтгэн дүгнэсэн болно.

4.7.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар тус төвлөрүүлэн захирагчид өгсөн 2 албан шаардлагын хэрэгжилтийг үнэлэхэд биелэлт 100.0 хувьтай байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Илрүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	2	-	2	-	100.0
Нийт дүн	2	-	2	-	100.0

4.8 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хүрээнд цахим паспорт, иргэний үнэмлэх болон бусад үнэт цаасны хоорондын тооцоо, улсын төсөвт төвлөрүүлэх орлогын бүрдүүлэлтийг дараагийн аудитаар авч үзнэ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 23 төсвийн байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэснээс 22 байгууллагад дүгнэлт гаргаж, 1 байгууллагыг түүвэрт хамруулсан байна. Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд "Өөрчлөлтгүй" 22 дүгнэлт өглөө.

Аудитаар нийт 1,346.8 сая төгрөгийн 46 зөрчил¹ илэрснээс 883.3 сая төгрөгийн алдааг залруулж, 1.2 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 254.5 сая төгрөгийн зөрчилд 11 албан шаардлага хүргүүлж, 207.7 сая төгрөгийн зөрчлийг арилгах 26 зөвлөмж өглөө.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 883.3 сая төгрөгийн 7 алдаа² илэрснээс аудитын явцад залрууллаа.

Төсвийн төвлөрүүлэн захирагч:

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийт 83.9 сая төгрөгийн 4 зөрчил илэрснээс, 38.8 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 45.1 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

5.1 Албан шаардлага

1. Харьяа газруудын төсвийн хуваарийг оновчтой төлөвлөж, хуваарилаагүйгээс Нийслэлийн улсын бүртгэлийн газрын төсвөөс УБЕГ-ын 38.0 сая, Хэнтий аймгийн УБХ-ийн 6.9 сая, Өвөрхангай аймгийн УБГ-ын 1.8 сая төгрөгийн НДШ-ийн өрийг барагдуулж, нэгтгэсэн тайланд хоорондын тооцоогоор устгалт хийсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх

2. Оны эцэст төсвийн зарцуулаагүй үлдэгдлийг төсөвт төвлөрүүлэлгүй, 2 аж ахуйн нэгж байгууллагатай архивын нягтруулсан шүүгээ нийлүүлэх 835.2 сая / харьяа 22 байгууллага 790.1 сая, УБЕГ 45.1 сая/ төгрөгийн гэрээ байгуулж, авлагыг нэмэгдүүлсэн байна.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

² Тайлагнасан санхүүгийн тайлангийн үзүүлэлт, тайлагнасан байвал зохих үзүүлэлтийн хоорондын зөрүү. Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.



Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Шийдвэрлэсэн нь: ХАА-ны төлөвлөгөөнд тусгаагүй хөрөнгө худалдан авахгүй байх, оны эцэст хөрөнгө худалдан авах гэрээ байгуулж, авлага үүсгэхгүй байх албан шаардлага хүргүүлэх.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Үнэт цаасны тооцоотой холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Гадаад паспорт болон иргэний үнэмлэхийн бэлдэц буюу үнэт цаасны бүртгэлд тавих хяналтыг хэрэгжүүлээгүй, үнэт цаасыг орлогод бүртгээгүй, зардалд шууд бүртгэсэн. Орлого бүрдүүлэлтийг үнэт цаасны бүртгэлтэй уялдуулж хянадаггүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.11-т "төсөв, санхүүгийн дотоод аудит, хяналт шалгалтыг зохион байгуулж, удирдлагаар хангах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж:

Үнэт цаасны тооцоог улирал бүр хийж, орлогын бүрдүүлэлтэд тавих дотоод хяналтыг сайжруулах

Арилжааны банкны данстай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт:

Улсын төсвийн орлого төвлөрүүлдэг нийт 31 данс ашиглаж байгаагаас Хас, Голомт, Төрийн банк дахь 19 данс, Голомт банкны 6 данс нийт 25 данс хааж, арилжааны банканд данс нээх СЯ-ны зөвшөөрөлгүйгээр шинээр Төрийн банканд 4, Голомт банканд 2 данс нээлгэн ашиглаж байна. Дээрх арилжааны банкнуудад дансыг олон дахин өөрчилж байгаа нь улсын төсвийн орлогын бүрдүүлэлт, хяналтад эрсдэл үүсгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.11-т "төсөв, санхүүгийн дотоод аудит, хяналт шалгалтыг зохион байгуулж, удирдлагаар хангах", Сангийн сайд, Монголбанкны ерөнхийлөгчийн 2012 оны "Засгийн газрын болон төсвийн байгууллагын дансыг Монголбанк, банкинд нээх, хаах журам"-ын 3.5-д Төсвийн байгууллага банкинд данс нээлгэх тухай хүсэлтийг дараахь мэдээллийн хамт албан бичгээр Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргад хаяглан ирүүлнэ" гэсэн заалтуудтай нийцээгүй.

2.2 Зөвлөмж

Ашиглагдахгүй байгаа арилжааны банк дахь данстыг хааж, холбогдох байгууллагаас зөвшөөрөл авч дансыг нээж, ашиглах

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 504.9 сая төгрөгийн 41 зөрчил илэрснээс, 84.3 сая төгрөгийн 6 алдааг залруулж, 1.2 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 215.7 сая төгрөгийн зөрчилд 9 албан шаардлага хүргүүлж, 162.6 сая төгрөгийн зөрчилд 24 зөвлөж хүргүүллээ.

Дээрх акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

6. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Д/д	Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж		
		Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Залруулсан		Залруулаагүй		Зөвлөмж		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
1	Булган аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс	2	7,269.3	1	2,269.3	1	5,000.0							
2	Дорноговь аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс	3	16,448.4	2	804.4	1	15,644.0	3	16,448.4					
3	Увс аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс	1	24,624.3			1	24,624.3	1	24,624.3					
4	УБЕГ-ын аппарат	1	834,923.2			1	834,923.2	1	834,923.2					
	Нийт	7	883,265.2	3	3,073.7	4	880,191.5	5	875,995.9					

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Д/д	Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Улсын бүртгэлийн ерөнхий газар												

СНАГ-2023/19/НА-СТА-ТТЗ



Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

1	Хэвлэх үйлдвэрт үнэмлэхийн материалыг бэлтгэж өгч байна. Үйлдвэрээс бэлэн болсон гадаад паспорт, иргэний үнэмлэхийг орлого авахгүй, бэлдэц материалын үнээр шууд зарлага болгож үйлдвэрээс гарч гадаад паспорт, иргэний үнэмлэхийн нэгжийн ертгийн тооцоог хийхгүй байгаагаас үйлдвэрийн ашиг алдагдлыг тооцох боломжгүй, бүртгэлээр тавих дотоод хяналт сул байна.	1	-	1	-	1	-	1	-	1	-	1	-	1	-	1	-	1	-
2	Оны эцэст төсвийн зарцуулаагүй үлдэгдлийг төсөвт төвлөрүүлгүй, 2 аж ахуйн нэгж байгууллагатай архивын нягтруулсан шүүгээ нийт 835,265.5 мянган /22 нэгж байгууллагад 790,165.5 мянга, УБЕГ-ын 45,100.0 мянга/ төгрөгийн худалдан авах гэрээ байгуулж, авлагыг нэмэгдүүлсэн байна.	1	45,000.0	1	45,100.0														
3	Нийслэлийн улсын бүртгэлийн газар нь ажил ологчоос төлөх НДШ-ийн зардлын төсвийн хэмнэлтээс УБЕГ-ын 38,790.9 мянга, Хэнтий аймгийн 6,913.5 мянга, Өвөрхангай аймаг 1,878.0 мянган төгрөгийн НДШ-ын өрийг төлж, нэгтгэсэн тайланд хоорондын тооцоогоор устгалт хийсэн байна	1	38,790.9	1	38,790.9														
4	Улсын төсвийн орлого төвлөрүүлдэг нийт 31 данс ашиглаж байгаагаас Хас, Голomt, Терийн банк дахь 19 данс, Голomt банкны 6 данс нийт 25 данс хаалтасан, арилжааны Банкнд данс нээх СЯ-ны зөвшөөрөлгүйгээр шинээр Терийн Банкнд 4, Голomt Банкнд 2 данс нээлтэсэн ашиглаж байна.	1	-																

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Харьяа байгууллагууд		Дүн	4	83,790.9	-	2	83,890.9	2	-	-	-
1	Архангай аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс	1	1,783.6		1	1,783.6					
2	Баянхонгор аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс	3	19,905.6				3	19,905.6			
3	Булган аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс	5	3,851.5	1	380.0	2	295.5	2	3,176.0		
4	Говь-Алтай аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс	2	166.0			1	166.0	1	-		
5	Говь сүмбэр аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс	2	3,500.3					2	3,500.3		
6	Өмнөговь аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс	4	333.5					4	333.5		
7	Сүхбаатар аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс	1	0.0					1	-		
8	Сэлэнгэ аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс	3	1,167.9			2	1,167.9	1	-		
9	Төв аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс	2	20,161.2			2	20,161.2				
10	Ховд аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс	1	699.2					1	699.2		
11	Хөвсгөл аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс	1	-					1	-		
12	Хэнтий аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс	1	858.8	1	858.8						
13	Дархан-Уул аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс	1	-					1	-		
14	Орхон аймаг дахь Улсын бүртгэлийн газар	2	19,844.0					2	19,844.0		
15	Нийслэл дэхь Улсын бүртгэлийн газар	3	65,969.0					3	65,969.0		
16	УБЕГ-ын аппарат /түүвэр/	3	241,391.6			1	192,181.6	2	49,210.0		
	ДҮН	35	379,632.2	2	1,238.8	9	215,755.8	24	162,637.6		
	Нийт дүн	39	463,423.1	2	1,238.8	11	299,646.7	26	162,637.6		

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Д/д	Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Үүнээс		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Төсвийн шууд захирагч									

СНАГ-2023/19/НА-СТА-ТТЗ

БЭРЧИЛЭЛТ 26
САНАЛ ДҮГНЭЭГ

/мянган төгрөгөөр/

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

1	Дорноговь аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс	1	-					1	-
2	Дорнод аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс	1	-					1	-
3	УБЕГ-ын аппарат гүүвэр/	1	1,353,374.5		1		1,353,374.5		
	Дүн	3	1,353,374.5		1		1,353,374.5	2	-



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 09 дугаар сарын 09 № 690/Н0170076

Улаанбаатар хот

СНАР-2023/19/НА-СТА-ТТЗ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төсвийн зарцуулаагүй үлдэгдлийг төсөвт төвлөрүүлэлгүй, 2 аж ахуйн нэгж байгууллагатай архивын нягтруулсан шүүгээ нийлүүлэх нийт 835,265,504.82 төгрөг, /22 нэгж байгууллагад 790,165,504.82 /Долоон зуун ерэн сая нэг зуун жаран таван мянга таван зуун дөрвөн төгрөг наян хоёр мөнгө/; УБЕГ-ын 45,100,000.00 /Дөчин таван сая нэг зуун мянга/ төгрөгийн худалдан авах гэрээ байгуулж, тайлант оны авлагыг нэмэгдүүлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах"; Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгөх", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-т заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй хөрөнгө худалдан авахгүй байх, тайлант онд авлага нэмэгдүүлэхгүй байх, албан шаардлагын биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
- Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга /Д.Дэлгэрсайхан/, Ахлах нягтлан бодогч /Ч.Баасансүрэн/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *Ц.Н* Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР *А* Ц.ХОСЖАРГАЛ
АХЛАХ АУДИТОР *В* В.ЭРДЭНЭЦОГТ
АУДИТОР *С* С.ОТГОНХОРЛОО

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

Э-Албан Шаардлага/2023-0111/СНАГ-180-193/1хх



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 03 дугаар сарын 29 № 691/40170076

Улаанбаатар хот

СНАГ-2023/19/НА-СТА-773
Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нийслэлийн Улсын бүртгэлийн газар нь ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлын төсвийг хэмнэлтээс УБЕГ-ын 38,790,971.98 /Гучин найман сая долоон зуун ерэн мянга есөн зуун далан нэгэн төгрөг ерэн найман мөнгө/, Хэнтий аймгийн 6,913,522.00 /зургаан сая есөн зуун арван гурван мянга таван зуун хорин хоёр/, Өвөрхангай аймгийн 1,878,000.00 /Нэг сая найман зуун далан найман мянга/ төгрөг, НДШ-ийн өрийг төлж, нэгтгэсэн тайланд хоорондын тооцоогоор устгалт хийсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-т заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Дээрх зөрчлийг давтан гарахгүй байх, албан шаардлагын биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга /Д.Дэлгэрсайхан/, Ахлах нягтлан бодогч /Ч.Баасансүрэн/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР		Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР		Ц.ХОСЖАРГАЛ
АХЛАХ АУДИТОР		В.ЭРДЭНЭЦОГТ
АУДИТОР		С.ОТГОНХОРЛОО



Төсөл

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Э: 48704049 | Email: audit@audit.gov.mn | 2023-03-29 | 14:05:10